



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2005 оны 3 сарын 18 өдөр

Дугаар 95

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалт, Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 15 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхэд залуучуудын газрын дүрмийг нэгдүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.

Хоёр. Батлагдсан дүрмийг мөрдөж ажиллахыг Хүүхэд залуучуудын газар /С.Алтанцэцэг/-т үүрэг болгосугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2001 оны 18 тоот захирамжийг хүчингүй болгосонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



**НИЙСЛЭЛИЙН ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН
ГАЗРЫН ДҮРЭМ**

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Засаг Даргын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхэд, Залуучуудын газар нь /Цаашид "Газар" гэх/ нь нийслэлийн нутаг дэвсгэрт хүүхэд залуучууд, гэр бүлийн талаар Монгол Улсын Засгийн газраас явуулах бодлого болон Нийслэлийн Засаг Даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Нийслэлийн засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлаг мөн.

1.2. Газар нь өөрийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжууд, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын захирамж, мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.3. Газар нь Нийслэлийн Засаг дарга, засаг даргын орлогч, Тамгын газарт ажлаа тайлагнана.

1.4. Газар тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудсыг хэрэглэж, банкинд данстай байна.

1.5. Газар нь хүүхэд залуучууд гэр бүл, эмэгтэйчүүдэд мэдлэг боловсрол олгох, авъяас чадварыг дэмжих чиглэлээр "сан"-тай байж болно.

Хоёр. Газрын удирдлага зохион байгуулалт

2.1. Нийслэлийн Засаг дарга нь Газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоож, газрын даргыг томилж, чөлөөлнө.

2.2. Газрын дарга нь Нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр орлогч даргаа томилж, чөлөөлнө.

2.3. Газрын дарга нь Монгол Улсын Хууль тогтоомж, удирдах дээд байгууллагын шийдвэрт нийцсэн тушаал гаргаж, биелэлтийг нь хангуулна.

2.4. Газрын дарга нь батлагдсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилж, чөлөөлнө.

2.5. Газар нь Хүүхэд залуучуудын хэлтэс, Захиргаа аж ахуйн тасаг гэсэн хоёр үндсэн нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулна.

2.6. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдтай Нийслэлийн Засаг даргын байгуулсан гэрээний үндсэн дээр Хүүхэд залуучуудын хэлтэс нь нийслэлийн төсвөөс санхүүжин үйл ажиллагаагаа явуулна.

2.7. Захиргаа аж ахуйн тасаг нь үйл ажиллагааны орлогоор зарлагаа санхүүжүүлэх зарчмаар ажиллана

2.8. Газрын даргын дэргэд байгууллагын зорилт үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж байх зөвлөлийг ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг газрын дарга батлана.

2.9. Газрын даргын ээлжийн амралт, удаан хугацааны сургалт, томилолт, чөлөөтэй үед газрын удирдлагыг орлогч дарга албан ёсоор гүйцэтгэнэ.

Гурав. Газрын үүрэг

3.1. Монгол Улсын Засгийн Газар, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх.

3.2. Холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Толослогчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, үүрэг даалгаврыг нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц үр дүни хугацаанд нь тайлагнаж ажиллах.

3.3. Хүүхэд, залуучууд, гэр бүл, эмэгтэйчүүдийн талаар төрөөс болон нийслэлээс баримтлах бодлого энэ чиглэлээр гарсан хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

3.4. Хүүхэд залуучууд, гэр бүл, эмэгтэйчүүдийн асуудлаар төрөлжсөн судалгаа хийж дүгнэлтүүдийг гарган энэ чиглэлээр хийх ажлуудыг тодорхой төлөвлөж хэрэгжүүлэх.

3.5. Хүнд нөхцөлд амьдарч буй хүүхдүүдийг асран хамгаалах, залуучуудын ядуурал хөдөлмөр эрхлэлтийн асуудалд тусгай хөтөлбөр боловсруулан ажиллах.

3.6. Харьяа газрууд ба хамтран ажилладаг байгууллагуудын болон анхан шатны байгууллагынхаа ажилтнуудыг мэргэжлийн хувьд чадваржуулах, давтан сургах, дэдлагажуулах арга зүйн болон мэргэжлийн удирдлагаар хангах, боловсон хүчний нөөцийн бодлого боловсруулах, зөвлөгөө өгөх.

3.7. Хүүхэд залуучуудын зориулалттай баригдсан барилга байгууламжийг зориулалтаар нь ашиглах, материаллаг баазыг бэхжүүлэхэд анхаарч тэдгээрийг түшиглэн хүүхэд залуучууд, гэр бүл, эмэгтэйчүүдэд зориулсан төрөл бүрийн сургалт, төвлөрсөн арга хэмжээнүүдийг зохион байгуулах.

3.8. Хүүхэд залуучууд, гэр бүл, эмэгтэйчүүдийг хөгжүүлэхэд чиглэгдсэн төслүүдийг боловсруулж зохих газруудад уламжлан дэмжүүлж хэрэгжүүлэх асуудлаар газрын дэргэд төслийн баг ажиллах.

3.9. Хүүхэд залуучууд, гэр бүл, эмэгтэйчүүдийн нийтлэг эрх ашгийг хамгаалах тэдэнтэй холбогдсон байгууллага, иргэдийн санал, өргөдөл гомдлыг хүлээн авч зохих газруудад уламжлан шийдвэрлүүлэх.

3.10. Эрхэлж буй ажлын хүрээнд хамаарах зайлшгүй шаардлагатай асуудлаар Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад асуудал боловсруулан оруулж нийгмийн хөгжлийн хэлтсээр уламжлуулан шийдвэрлүүлэх.

3.11. Газрын даргын нийтлэг хэм хэмжээ тогтоосон тушаалыг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэст ирүүлж хянуулах.

3.12. Байгууллагын хэмжээнд сахилга, дэг журам, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, омч хоронгийн хадгалалт хамгаалалт, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллах.

3.13. Хүүхдийн сургалт хүмүүжлийн тусгай төв, Амьдрах ухаан сургалт үйлдвэрлэлийн тусгай товийн үйл ажиллагаанд мэргэжлийн пдэмжлэг туслалцаа үзүүлэх, хүүхэд өсвөр үеийнхний эрхийг хамгаалах, тэднийг гэр бүл, сургууль хамт олны дунд төлөвшүүлэх, мэргэжлийн чиг баримжаа олгох нөхцөлийг бүрдүүлэхэд судалгаа дүгнэлттэй ажиллах.

3.14. Хүүхэд, залуучууд, гэр бүл, эмэгтэйчүүдийн асуудлыг хариуцан ажилладаг төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах.

Дөрөв: Газрын эрх

4.1 Хүүхэд, залуучуудын талаар төрөөс баримтлах бодлого, үйл ажиллагааны чиглэлийг нийслэлд хэрэгжүүлэхтэй холбогдсон саналыг боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тавьж шийдвэрлүүлэх

4.2. Нийслэлийн дүүрэг хороодод хүүхэд залуучуудын асуудал эрхэлсэн ажилтнуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагааны тайлан сонсголыг хэлэлцэн үүрэг даалгавар өгөх, биелэлтийг хангуулах, зөрчил дутагдлыг арилгах

4.3 Эрхэлсэн асуудалтай холбоотой судалгаа, баримт материалыг төрийн захиргааны болон бусад байгууллагуудаас тогтоосон журам, эрх хэмжээний дагуу гаргуулан үйл ажиллагаандаа хэрэглэх

4.4. Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан хүмүүсийг төр засгийн болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шагналд уламжлах, газрын шагналаар шагнах

4.5. Хүүхдийн зуслангийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах

4.6. Газрын эрхэлж буй асуудлаар семинар, зөвлөгөөн, сургалт зохион байгуулах, туршлага судлах, солилцуулахаар гадаад дотоодын курс, семинарт ажилтнуудыг хамруулах асуудлаар саналаа холбогдох байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх

4.7. Газар нь хүүхэд, залуучууд, гэр бүл эмэгтэйчүүдийн асуудлаар гарч буй дэвшилтэт тэргүүн туршлага, ололт амжилт, дутагдал доголдол шийдвэрлэх арга замын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа явуулах

4.8. Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн болон хууль тогтоомжоор олгогдсон бусад эрхийг эдлэх

Тав. Газрын үйл ажиллагааны чиглэл

5.1 Газар нь ажлаа жил, улирлаар төлөвлөж, төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган нийслэлийн засаг даргын тамгын газарт хүргүүлнэ.

5.2. Газрын дарга нь холбогдох хууль тогтоомж, энэ дүрэм, нийслэлийн засаг даргаас өгсөн удирдамжийн дагуу газрын ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан батлуулж, тэдний өдөр тутмын ажлыг шуурхай удирдлагаар ханган, цаг үеийн ажлыг шуурхай зохион байгуулж дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

5.3. Ажилтан бүрийг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээтэйгээр ажиллуулж, хагас, бүтэн жилээр ажлын тайлан гаргуулан хэрэгжилтэнд нь хяналт тавьж, мэргэжлийн ур чадварын түвшинг тогтоож ажиллана.

5.4. Газрын дотоод ажлыг зохион байгуулж хууль тогтоомж шийдвэр, засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, захирамж, тухайн жилийн эдийн засаг, нийгмийн зорилт, удирдлагуудаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг биелүүлэхийн тулд газрын ажилтнуудад хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтэнд нь хяналт тавьж ажиллана.

5.5. Газрын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд хөтөлбөр, төсөл, захирамж, журам зэрэг баримт бичгийн төсөл боловсруулж удирдах дээд байгууллагаар шийдвэрлүүлнэ.

5.6. Газрын нэрийн өмнөөс нийслэлийн нутаг дэвсгэр дэхь төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж иргэдтэй хамтран ажиллана.

5.7. Газрын эрх хэмжээнд багтсан асуудлаар даргын зөвлөлийн хурлыг 14 хоног тутамд хийж, нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын удирдах хариуцлагатны шуурхай зөвлөгөөний явц, удирдлагуудаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх болон газрын ажилтнуудаас хариуцан гүйцэтгэх цаг үеийн ажил, албан хаагчдын ёс зүй, хариуцлага, санаачлага, өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт ажлын арга барил үр нөлөөг сайжруулах асуудлыг хэлэлцэж протокол хөтөлнө.

5.8. Газар нь ажилтнуудынхаа мэдлэг, мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг (ажлын байрнаас нь хөндийрүүлэлгүй) үе шаттай зохион байгуулж ахмад залуу үеийн, шинэ ажилтнуудын ажлын дадлага туршлагыг харилцан солилцуулах бодлогыг тууштай баримтлан ажиллана.

5.9. Газар нь ажилтан, ажилчдынхаа нийгмийн асуудлыг бодитой шийдвэрлэхэд анхаарч тэдний ажлын байрны тав тухтай орчныг бүрдүүлэх, ахуй амьдралд нь туслалцаа үзүүлэх /байр орон сууцны нөхцөл хангамжийг дээшлүүлэх/, хамт олныг бүрдүүлэн төлөвшүүлэх, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн төрөл бүрийн арга хэмжээг авч ажиллана.

5.10. Газар нь ажилтан, ажилтнуудынхаа эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлтөөс урьдчилан сэргийлэх, чийрэгжүүлэх зэрэг бүх төрлийн арга хэмжээг шат дараалан авч засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу эрүүл мэндийг дээдлэгч байгууллага болж ажиллана.

Зургаа. Хүлээх хариуцлага

6.1. Газрын дарга, орлогч дарга, ажилтнууд нь бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ болон энэхүү дүрмээр хүлээсэн үргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

Долоо. Бусад эрх

7.1. Энэхүү дүрэмд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

7.2. Энэхүү дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр зохих эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

-----oO-----